



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 28 өдөр

Дугаар A/1033

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а", 29.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.17 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан 2022 оноос эхлэн нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх Хотын стандартыг боловсруулах, батлуулах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Хотын стандартыг боловсруулах ажлыг 2022 оны 03 дугаар сарын 01-ний дотор зохион байгуулж явц үр дүнг тухай бүр танилцуулахыг Ажлын хэсэг (Р.Дагва)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

111020004960